

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ДӨРВӨН ОНОЛЫН
МӨН ЧАНАР, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

М.Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн тэргүүлэх профессор, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Түлхүүр үг: либертари онол, авторитари онол, хариуцлагатай эрх чөлөөний онол, коммунист онол.

Б арууны орнуудад түгээмэл хэрэглэдэг ОНМХ-ийн нийгмийн хариуцлагын тухай дөрвөн гол онол байдаг. Энэ онолыг 1956 онд АНУ-ын хэвлэлийн онол, түүхийг судлаачид, нэрт эрдэмтэд Фред Сиберт, Теодор Петерсон (Иллинойсын их сургууль), Уилбур Шрамм (Стэнфордын их сургууль) нар анх боловсруулж, бие даасан ном болгон хэвлэн гаргажээ. Ийм онолыг боловсруулж, бие даасан ном болгон хэвлэхэд нөлөөлсөн хүчин зүйл бол 1942 онд "Time" сэтгүүлийн эзэн Генри Люсын санаачлага, санхүүгийн дэмжлэгээр байгуулагдсан Хэвлэлийн эрх чөлөөний комиссын дүгнэлт юм. Чикагогийн их сургуулийн ерөнхийлөгч Р.М. Хатчинсын тэргүүлсэн комиссын гол зорилго нь хэвлэлийн эрх чөлөөнд аюул

учирч байгаа эсэхийг тодруулахад оршиж байсан бөгөөд АНУ-д хэвлэлийн эрх чөлөөг зөрчиж байгааг тодорхой жишээ, баримтаар баталсан дүгнэлтийг "Чөлөөт ба хариуцлагатай хэвлэл. Олон нийтийн харилцааны хэрэгслийн (сонин, радио, телевиз, сэтгүүл ба ном) тухай ерөнхий илтгэл" нэртэй 1947 онд хэвлэгдэн гарчээ. Мөн У.Э.Хокинг сэтгүүлчдийн кодекс болон хэвлэлийн практикийн үндсэн дээр мэргэжлийн ёс зүйг тэргүүн зэрэгт тавьсан нийгмийн хариуцлагын онолын үндсэн үзэл баримтлалыг боловсруулсан байна. Үүний дараа У. Шрамм Сүм хийдийн үндэсний зөвлөлийн Сүм хийд ба эдийн засгийн амьдралын хэлтсийн захиалгаар ОНМХ-ийн төлөөлөгчдийн нийгмийн хариуцлагыг судлах төслийн хүрээнд "хэвлэл мэдээллийн дөрвөн онол"-ыг боловсруулсан юм. Судлаачид хэвлэл мэдээллийн нийгмийн хариуцлага нь ХМХ үйл ажиллагаа явуулж буй тэр нийгэм-улс

төрийн тогтолцооноос шалтгаалж түүнд тохирсон онцлогтой бий болжээ гэсэн гол дүгнэлт хийж, үүнийг *авторитари, либертари, нийгмийн хариуцлага, зөвлөлтийн коммунист* онол гэж нэрлэсэн байдаг.

Авторитари үзэл баримтлал нь ХМХ зөвхөн хаан, фюрер, эзэн, төр засгийн өмнө хариуцлага хүлээдэг гэдгийг тогтоож өгсөн бол хэвлэлийн эрх чөлөөний буюу либертари онол нь тийм хараат байдал, хэвлэл төрийн зэвсэг байх ёстой гэсэн үзэл баримтлалыг үгүйсгэж, хэвлэл төрийн зүгээс тавих аливаа хяналтаас ангид чөлөөтэй байхын хамт төрийн гурван өндөрлөгөөс хараат бус байж, төр засгийг хянах замаар "дөрөв дэх засаглал"-ын үүргийг гүйцэтгэдэг гэж үздэг байна. Тэгвэл нийгмийн хариуцлагын онол либертари чиглэлийг хэвлэл мэдээллийн төвлөрөл, монополчиллын шинэ нөхцөлд тохируулан хөгжүүлсэн бөгөөд гол санаа нь ХМХ нийгмийн эрх ашгийг харгалзан үзсэний үндсэн дээр тодорхой хэмжээгээр эздээс хараат бус, бие даасан байдалд үйл ажиллагаа явуулах ёстой гэдэгт оршино. Зөвлөлтийн коммунист онол нь ХМХ коммунист намын зэвсэг, мэдээллийн хэрэгсэл байх ёстой гэсэн авторитари үзэл баримтлалын нэг хувилбар юм. Дөрвөн онолыг боловсруулагчдын гол зорилго нь хэвлэл мэдээлэл, төр засаг ба иргэдийн хоорондох харилцан үйл ажиллагаа,

харилцан нөлөөллийн зарчмууд, онолын талууд, философид гол анхаарлаа төвлөрүүлэхэд чиглэгдсэн байна. Нийгмийн болон иргэдийн өмнө хэвлэл мэдээллийн хүлээх хариуцлагын асуудлууд өнөөдөр хүртэл шийдвэрлэгдээгүй, хурц асуудал хэвээрээ байгаа бөгөөд байнгын хөгжил, хөдөлгөөнд оршдог онцлогтой юм. Одоогоос 50 жилийн өмнө боловсруулсан Р.Хатчинсын Комиссын тогтмол хэвлэлийн нийгмийн хариуцлагын тухай үзэл баримтлал нь зарим нэг үл гүйцэлдэх шинжтэй боловч өнөөдөр хүртэл АНУ-ын хувьд ч, манай орны хувьд ч үнэ цэнэ, ач холбогдоллоо алдаагүй байна.

Хэвлэл мэдээллийн авторитари онолыг гүнзгий ойлгохын тулд *авторитаризм* хэмээх ойлголтын талаар мэдэх шаардлагатай болдог. Авторитаризм гэдэг нь: 1. Нэг хүн, бүлэг, нам эвслийн монопол засаглал, уг тогтолцоог эсэргүүцэхгүй бол бүх талын плюрализмыг зөвшөөрдөг, нийгмийн амьдралын талуудыг харилцан адилгүй зохицуулдаг, төр нийгмийн дээд институт болдог, уламжлалт нийгмийн тогтолцоог хадгалах эрмэлзэл бүхий түүхийн хувьд урт удаан хугацааны баялаг түүхтэй улс төр-нийгмийн тогтолцоо. 2. Улс төрийн дарангуйлалт дэглэмийн хэлбэр юм.

Хэвлэл мэдээллийн дөрвөн онолын дотроос хамгийн ууган нь авторитари онол бөгөөд Сэргэн мандалтын сүүлийн шатанд хэвлэлийн суурь машин

бүтээсний дараах үеийн авторитари дэглэмийн үед үүссэн байна. Дараа нь Англид XVI-XVII зууны үед өргөн дэлгэрчээ. Дэлхийн зарим оронд өнөөдөр ч энэ онол хүчтэй хэвээр байна.

Авторитари үзэл баримтлалын хамгийн дээд илэрхийлэл нь тоталитар шинж бөгөөд гол утга нь мэдээллийн үйл ажиллагааны эрх чөлөөг гагцхүү ноёрхож буй төр, засаг эдлэх ёстой гэдэгт оршино. Энд төр, засаг эдийн засаг, үзэл суртлын хувьд ноёрхож буй хүчнүүдийн улс төрийн эрх ашгийг иш үндэс болгодог. Тиймээс энэ хүчнүүдийн гаргаж буй ОНМХ-үүд нь хэмжээгүй эрх чөлөө (түүний дотор бодит байдалд үл нийцэх, худал

«
Авторитари үзэл баримтлалын хамгийн дээд илэрхийлэл нь тоталитар шинж бөгөөд гол утга нь мэдээллийн үйл ажиллагааны эрх чөлөөг гагцхүү ноёрхож буй төр, засаг эдлэх ёстой гэдэгт оршино. Энд төр, засаг эдийн засаг, үзэл суртлын хувьд ноёрхож буй хүчнүүдийн улс төрийн эрх ашгийг иш үндэс болгодог.
»

хуурмаг мэдээллийг хүртэл тараах эрх чөлөө) эдлэх эрхтэй байдаг. Ийм нөхцөлд өөрөөр сэтгэгчдийг сэтгүүл зүйн салбарт огт нэвтрүүлэхгүй, эсвэл тэдний ХМХ-ийг янз бүрийн аргаар хавчин хянаж, олон ургалч үзлийг хориглох, дээд зэргээр хязгаарлах болон төр, засгийн эрх ашгийн үүднээс хүлээн авагчдад нөлөөлөх зорилгоор эдийн засгийн байнгын дарамт шахалт үзүүлэх болно. Хэвлэлийн эрх чөлөөнд хандах авторитари хандлага бол ноёрхож буй аливаа хүчний гол шинж юм. Учир нь тэд

нийгмийн амьдралын үндсэн асуудлын талаарх өөрсдийн үзэл бодлыг бусад хүчнүүдтэй харьцуулахад туйлын биш юмаа гэхэд дээд зэргээр үнэн зөв гэж үздэг.

Авторитари хандлага ардчилсан нийгэмд ч ажиглагдах онцлогтой. "Шинэ залуу" ардчиллын нөхцөлд сонгуульд ялсан хүчнүүд өөрсдийн хөтөлбөр, зорилгыг аль болохоор өргөн хүрээнд

хурдан шуурхай хэрэгжүүлэхийн тулд сөрөг хүчинд "дарамт үзүүлэх", тэдний олон түмэнд нөлөөлөх боломжийг хязгаарлах, засгийн газрын үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа үйлдлийн эсрэг түүний шударга байдлыг үл харгал-

зан саад бэрхшээл учруулах явцад ажиглагддаг¹.

"Зөөлөн" авторитаризм ийм байдлаар бий болдог. Гэхдээ түүний үндсийг бүрдүүлэгч хамгийн аятайхан хүсэл сонирхол хүртэл ардчиллыг хязгаарлах байдлаар илэрдэг. Энэ нь улс төрийн соёлын дутагдал, сул тал, аливаа шүүмжлэлийг харгалзан үзэх, оновчтой шийдвэр гаргах, эрж хайх явцад сөрөг хүчинтэй маргаан, мэтгэлцээн, явуулах болон харилцан зөвшилцөх яриа хэлэлцээр өрнүүлэх чадвар тааруу байгаагийн

илрэл юм. Ардчиллыг хөгжүүлэх явц дахь дутагдал, эсвэл түүнээс ухрах байдлаар илэрдэг "зөөлөн" авторитаризмыг ардчиллын эсрэг бүдүүлэг чиг баримжаа, үйлдлээс ялгаж үзэх шаардлагатай. "Бүдүүлэг" авторитаризмын гол шинж нь хатуу хяналт тавих, хавчин мөрдөх, шаардлагатай үед хүч хэрэглэх, ялангуяа олон түмний өргөн дэмжлэгийг авах боломжтой хүчнүүдэд дарамт үзүүлэх, тэдний төрийн институтын шийдвэрт нөлөөлөх боломжийг хязгаарлах замаар засгийн эрхийг олж авах, хадгалах хүсэл сонирхол байдаг.

“**А**вторитари онолын үндэс суурь нь хэмжээгүй эрхт хаан, түүний засгийн газар эсвэл хоёулангийн философи байдаг. Гол зорилго нь тэдний бодлогыг дэмжих, хэрэгжүүлэх, үйлчлэхэд оршино. Тоталитар дэглэмтэй оронд засгийн газрын онцгой зөвшөөрлийг авсан этгээд л ХМХ-ийг эрхлэн гаргадаг”². Улс төрийн машин болон түшмэлүүдийг шүүмжлэхийг хатуу хориглодог.

Хэвлэл мэдээллийн коммунист онол бол авторитари онолын шинэ нөхцөл дэх шинэ хувилбар бөгөөд хэвлэл мэдээлэл марксист детерминизмд үндэслэгдсэн, хүн амын ердөө аравхан хувийг эзэлдэг коммунист намын удирдлагыг дэмждэг, нам, төр засгийн зэвсэг болох ёстой гэсэн үзэл баримтлал юм. Гэхдээ авторитаризмын хуучин хувилбараас ялгагдах онцлог нь сэтгүүл зүй

хувийн хэвшлийнхний мэдэлд бус зөвхөн төр засгийн мэдэлд байдаг. Энд ашиг орлогын тухай ойлголт байх ёсгүй, бодит эрх чөлөөний тухай ойлголт сөрөг эрх чөлөөний тухай ойлголтоор солигддог. Хүн төрөлхтний түүхэнд ямар ч хэвлэл тийм хатуу хяналтанд байгаагүй бөгөөд Зөвлөлтийн нэрийн өмнөөс яригчид өөрсдийн хэвлэлийг чөлөөт гэж үздэг байсан. Учир нь түүнийг удирдаж буй намын бодлого, үзэл бодлыг, “үнэн” үгийг тэд чөлөөтэй илэрхийлдэг. Тэд Америкийн хэвлэл бизнес учраас жинхэнэ чөлөөт хэвлэл биш, тиймээс хатуу хяналтын дор байдаг, марксист “үнэнийг” хэзээ ч чөлөөтэй ярьж чадахгүй гэж үздэг. Ийм үзэл бодлын үүднээс энэ хоёр систем өөрсдийн үйл ажиллагааг тодорхойлохын тулд хэдийгээр эрх чөлөө, хариуцлага гэдэг үгийг хэрэглэдэг боловч өөрсдийн үзэл бодол, үндэслэлийн хувьд эсрэг тэсрэг байр суурь баримталж байв. Америкийн сэтгүүл зүй үнэнийг олоход хувь нэмэр оруулахыг зорилго болгодог бол Зөвлөлтийн хэвлэл мэдээлэл марксист, ленинист, сталинист бэлэн үнэнийг олон түмэнд сурталчлахыг чухалчилдаг байжээ. Америкчууд өөрсдийн ХМХ-ийн уншигчдыг худал хуурмаг зүйлээс үнэнийг ялгаж чаддаг “сэтгэгч хүмүүс” гэж үздэг бол Зөвлөлтийнхэн тэдний уншигчид удирдлагын зүгээс анхааралтай удирдан чиглүүлэхийг хүсдэг учраас зөвлөлтийн төр засаг өрсөлдөгч мэдээллийн эсрэг

найдвартай хаалт хийдэг гэж үздэг. Америкчууд үзэл бодолд болон мэдээллийн өрсөлдөөний төлөө чадах бүхнийг хийдэг бол зөвлөлтийн мэдээллийн сувгаар зөвхөн коммунист намын бодлогыг хатуу барьсан нэг л чиглэлийн мэдээлэл цацахын төлөө ажилладаг байв. Америкчууд тэдний хэвлэл эрх чөлөөгүй, хатуу хяналтанд байдаг гэж ярьдаг бол Оросууд тэдний хэвлэлд ямар ч хариуцлагын мэдрэмж алга гэж үздэг байлаа.

Хэвлэл мэдээллийн коммунист онол анх ЗХУ-д үүссэн бөгөөд түүний зарим элементүүдийг нацистууд, итальянчууд дэлхийн олон орны практикт хэрэгжүүлсэн түүхтэй. Энэ онолын үндэс суурь нь Гегель болон XIX зууны философийн үзэл баримтлалыг хосолсон марксист, ленинист, сталинист сургаал мөн. Гол зорилго нь Зөвлөлтийн социалист системийн ололт амжилтыг болон коммунист намын диктаурыг сурталчлах, дэмжихэд оршино. ХМХ-ийг гол төлөв коммунист намын шалгарсан итгэлтэй гишүүд ашиглах, эрхлэн гаргах эрхтэй. Хэвлэл мэдээллийг төр, засгийн улс төр, эдийн засаг, хяналтын байгууллагууд хатуу хянадаг. Нам, төр засгийн бодлогыг шүүмжлэх, түүнийг намын практик үйл ажиллагаанд тараахыг хатуу хориглодог. Бусад онолоос ялгагдах гол онцлог нь ОНМХ бүхэлдээ төр, засгийн мэдэлд байдаг бөгөөд түүнийг хатуу хянаж, өөрийн үзэл суртлын зэвсэг болгон ашигладаг явдал юм.

Энэ онол 1990-ээд он хүртэл буюу үзэл суртлын хоёр систем ноёрхож байсан үед маш хүчтэй байр суурийг эзэлж, социалист системийн бүх орны хэвлэл мэдээллийн талаар баримталдаг онолын гол үзэл баримтлал байсан. Социалист систем нурж, "хүйтэн дайн" эцэс болсноор энэ онол түүх болон үлдсэн боловч сэтгүүл зүйн коммунист онол БНХАУ, Куба, БНАСУ зэрэг зарим оронд урьдын адил ноёрхсон хэвээр байна.

Улс төрийн ардчилал, шашны эрх чөлөө хөгжиж, чөлөөт худалдаа өргөжиж, улс орнуудаар айлчлах боломж нээгдэж, чөлөөт өрсөлдөөний эдийн засагт шилжиж эхэлсэн явдал болон Соён гэгээрлэлтийн үеийн гүн ухааны уур амьсгал авторитаризмын үндсийг таслахад нөлөөлж, хэвлэл мэдээллийн өөр үзэл баримтлалыг шаардаж эхэлжээ. ХҮII зууны эцэст үүсч, ХҮIII зуунд төлөвшиж, XIX зуунд цэцэглэн хөгжсөн энэхүү шинэ онол бол либертари онол юм. Үүнийг заримдаа хэвлэлийн бүрэн эрх чөлөөний онол гэж нэрлэдэг.

Анх Англид 1688 оноос хойш үүсч, дараа нь АНУ-д өргөн нэвтэрсэн, дэлхийд хамгийн түгээмэл тархсан үзэл баримтлалын нэг юм. Анх Ж.Мильтон, Ж.Локк, Ж.С.Миллийн бүтээлүүдэд болон рационализм ба байгалийн эрх зүйн философид тусгалаа олсон. Гол зорилго нь мэдээлэх, зугаацуулах, үнэнийг олоход туслах, төр засгийг хянахад

оршино. Дайн байлдааны үед төр, засгийн эсрэг сурталчилгаа явуулах, гүтгэх, доромжлох, ёс зүйгүй, зохимжгүй үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Сэтгүүл зүйн бусад онолоос төр, засгийн газрыг хянах зэвсэг болох, нийгмийн бусад хэрэгцээг хангах онцлог шинжээрээ ялгаатай. Хөрөнгө мөнгөтэй ямар ч хүн ХМХ-ийг эрхлэн гаргахыг зөвшөөрдөг. "Үзэл бодлын чөлөөт зах зээлд" үнэнийг олох боломж болон шүүх хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг хянадаг.

Авторитари байр суурийг баримталдаг ноёрхож буй хүчнүүдтэй хийх тэмцлийн явцад дэвшилт үзэлтнүүд хэвлэлийн бүрэн эрх чөлөөний талаарх өөрсдийн үзэл бодлыг дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж байв. Эрх зүйн түүхэн шаардлагуудын нэг бол ХҮII зууны үед үүссэн хэвлэлийн эрх чөлөөний талаарх лоозон байжээ. Энэ нь ХҮII зуунд хувьсгалт ардчилсан хүчнүүдийн хэвлэлийн салбарт авторитаризмын үзэл санааг хатуу барьж байсан феодалын хэмжээгүй эрхт хаант засаглалтай тэмцэх явцад дэвшүүлсэн гол шаардлагуудын нэг болсон юм.

Ер нь хөрөнгөтний гэгдэж байсан тэр нийгэмд бүр ХҮII-ХҮIII зууны үед хэвлэлийн эрх чөлөөг хүндлэн дээдэлж, чөлөөт хэвлэл бол ардчиллыг хөгжүүлэх гол хүчин зүйл мөн гэж үзэж байв. Ардчилсан нийгэмд ямар ч хориг, хязгааргүй, "чөлөөт" хэмээх үгийн жинхэнэ

утгаар нь үйлчилдэг чөлөөт хэвлэл ус, агаар шиг хэрэгтэй гэдгийг тухайн үеийн нийгэм, улс төрийн зүтгэлтнүүд, эрдэмтэн мэргэд хатуу баримтлаж, тийм хэвлэлийг бий болгохын төлөө хүчин зүтгэж байсан нь чөлөөт сэтгүүл зүйг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулжээ. Ардчиллын төлөө цогтой тэмцэгч, Америкийн ХҮI ерөнхийлөгч Абрахам Линкольн "өөрийнхөө дайсан хүртэл чөлөөт хэвлэлтэй байхын төлөө амь насаа зориулахад бэлэн байна"³ гэж уриалж байсан бол Английн яруу найрагч, улс төрийн зүтгэлтэн Жон Мильтон парламентад хэлсэн үгэндээ: "Боломж бүхий бүх төрлийн үзэл бодлын салхи чөлөөтэй салхилж байг. Үзэл бодлын чөлөөт зах зээл бий болсон үед л үнэн худлыг ялж чадна. Үнэн гэдэг бол хамгаас хүчтэй. Тиймээс хүнд худал хуурмагийн эсрэг чөлөөтэй, ил тод тэмцэх боломж олгох хэрэгтэй. Энэ бол шударга бус явдлын эсрэг тэмцэх хамгийн найдвартай, цорын ганц зөв зам мөн"⁴ гэжээ. Францын их хувьсгалын нэрт зүтгэлтэн, улс төрийн удирдагч М.Робеспьер ч энэ байр суурийг баттай баримтлагч байсан бөгөөд "хэвлэлийн эрх чөлөө гэдэг бол бүх төрлийн үзэл бодлыг чөлөөтэй нийтлэх явдал"⁵ гэдгийг нэг бус удаа цохон тэмдэглэжээ. Тэр "Хэвлэлийн эрх чөлөөний тухай үг"-эндээ: "Хүн болгонд заяасан эгэл жирийн оюун санаа, сайн мууг ялгах чадвар нь нэг үзэл бодлыг авч хаях,

нөгөө үзэл бодлыг сонгож авахад сургадаг. Хүмүүсийн энэхүү оюун ухаан, чадварыг хаан боогдуулж, өөрийнхөө явцуу эрх ашгийг түүнээс дээгүүр тавих нь үнэхээр тэнэг хэрэг" гэсэн нь санамсаргүй зүйл биш ажээ. Өрнөдийн улс орнуудын түүхэнд чөлөөт сэтгүүл зүйн гүйцэтгэсэн үүрэг, ардчиллыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр их байсан бөгөөд түүнийг хөгжүүлэхэд ардчилсан үзэлтнүүд чухал нөлөөтэй байсныг дээрх жишээ баримтаас ойлгож болох байна.

XIX, XX зууны үед феодалын эсрэг хөдөлгөөн өрнөсөн орнуудад ч хэвлэлийн эрх чөлөөний лоозон дээрхийн адил байв. 1644 онд хэвлэгдсэн Жон Мильтоны хэвлэлийн эрх чөлөөний үзэл санааг хүчтэй хамгаалсан "Ареопагитика" бүтээл нь 1907 онд Орост орчуулагдаж хэвлэгдсэн нь санамсаргүй тохиолдол биш байлаа. Феодализмтай тэмцэгчдийн дэвшүүлсэн хэвлэлийн эрх чөлөөний талаарх лоозон нь үзэл бодлын чөлөөт зах зээлийг шаардаж байв. Тэд феодалын хаант засаглалын хэвлэл чөлөөтэй байгаа нөхцөлд сэтгүүл зүйн бусад бүх "хэсэг, бүлэг" нь тэдний нэгэн адил эрхийг бодитойгоор эдлэх ёстой гэдгийг илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл, феодалын эсрэг тэмцэгчдийн эдийн засгийн болон нийгэм-уран бүтээлийн хувьд чөлөөтэй байсан сэтгүүл зүй нь нийгмийн дэвшил, түүний эрх ашгийн төлөө дээд зэргээр бүрэн чөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломж олж авахыг

шаарддаг байв. Хууль хяналтын хүчнүүд энэ лоозонгийн утга санааг сайн ойлгож байсан учраас түүнийг хэрэгжүүлэхэд янз бүрийн аргаар эсэргүүцэл үзүүлж, зөвхөн зарим тохиолдолд нийгмийн дэвшилтэт давхаргын шахалтаар хэсэгчилсэн буулт хийдэг байлаа. Лоозонг бүрэн хэрэгжүүлэх боломж зөвхөн тэдний ялалтын дараа л олдсон юм.

Тэдний дэвшүүлж байсан хэвлэлийн эрх чөлөөний тухай лоозонгийн агуулга нь нэлээд "цэвэр ариун" байсан бөгөөд бүхнийг хийх туйлын эрх чөлөө, хүнлэг бус, ёс суртахуунгүй юм хийхийг ерөөсөө шаардаагүй байсанд оршино. Лоозонг хамгаалагчид юуны өмнө ноёрхож буй хүчнүүдийн эсрэг өөрсдийн үзэл бодлыг сэргэлдүүлэн тавих бодомж олж авсан юм. Тэдний үзэл баримтлалын гол утга нь *нэгдүгээрт*, үзэл бодлын зах зээлд янз бүрийн санаа бодлыг чөлөөтэй нэвтрүүлэн оруулахын тулд бүх төрлийн санаа бодол, үзэл онолыг чөлөөтэй нийтлэх шаардлагатай. *Хоёрдугаарт*, нийгмийн амьдралд оролцогч, үйл ажиллагаа явуулж буй улс төрийн хүчнүүдийг бүрдүүлэгч хүн бүрд "боломж бүхий бүх сургаалын салхи" хүрсэн байх ёстой. *Гуравдугаарт*, хэрэв олон түмэн янз бүрийн үзэл бодол, түүний үндэслэлтэй танилцах боломжтой бол олон янзын маргаан, мэтгэлцээн, үнэлэлт дүгнэлтийн тэмцэлд оролцох бөгөөд ийм нөхцөлд үнэн хэзээ ч хүчтэй учраас

хүлээн авагч өөрийн эрхгүй үнэн үзэл бодлыг дэмжиж, худал хуурмаг, шударга бус юм ялагдал хүлээх зэрэг болно.

Хэвлэлийн бүрэн эрх чөлөө туйлын буянтай зүйл гэдэгт итгэх итгэл феодалын харгис хүчнүүд ялагдаж ардчилсан хөрөнгөтний нийгмийн тогтолцоо үүссэнээр улам бэхжиж, хүчтэй болсон юм. "Эзэрхэг засгийн

хэлтэрхий" доор босгосон шинэ нийгмийн Үндсэн хуулийн хэм хэмжээ нь хэвлэлийг төрийн зүгээс тавих аливаа хяналтаас чөлөөлөх явдал байв. Үүнийг АНУ-ын Үндсэн хуулийн анхны нэмэлт өөрчлөлтөнд бүрэн гүйцэд илэрхийлсэн бөгөөд энэ

бол "Шашны асуудлыг хөндсөн буюу чөлөөтэй шүтэж бишрэхийг хориглосон, аль эсвэл үг хэлэх, хэвлэн нийтлэх хийгээд ард олон санал гомдлоо илэрхийлсэн өргөх бичиг барин засгийн газарт хандаж, тайван жагсаал хийх эрхийг нь хязгаарласан хуулийг конгресс гаргах ёсгүй" гэсэн заалт юм. Хожим XIX, XX зууны үед батлагдсан ардчилсан тогтолцоо бүхий хөрөнгөтний орнуудын Үндсэн хуулинд хэвлэлийн эрх чөлөөг бүр ч тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, Германы Үндсэн хуулинд: "хүн болгон өөрийнхөө үзэл бодлыг бичгээр,

амаар, дүрслэх ... аргаар чөлөөтэй илэрхийлэх болон түгээх эрхтэй. Хэвлэлийн эрх чөлөө болон радио, кино мэдээллийн эрх чөлөө баталгаатай. Цензурыг хориглоно" гэж заажээ.

XX зуунд коммунист орнуудад авторитаризмын шинэ хэлбэр, коммунист бус орнуудад либертари онолын шинэ

хэлбэр үүсэх хандлага хүчтэй ажиглагдах болсон. Энэхүү либертари онолын шинэ хэлбэрийг нийгмийн хариуцлагын онол, эсвэл хариуцлагатай эрх чөлөөний онол гэж нэрлэдэг. Либертарийн шинэ хэлбэр Р.Хатчинсын Комиссын илтгэл хэвлэгдэн

«
XX зуунд коммунист орнуудад авторитаризмын шинэ хэлбэр, коммунист бус орнуудад либертари онолын шинэ хэлбэр үүсэх хандлага хүчтэй ажиглагдах болсон. Энэхүү либертари онолын шинэ хэлбэрийг нийгмийн хариуцлагын онол, эсвэл хариуцлагатай эрх чөлөөний онол гэж нэрлэдэг.

»

гарсны дараа олон нийтийн анхаарлыг ихээхэн татах болсон ч хэвлэн нийтлэгчид, сонин хэвлэлийн эрхлэгчид энэ онолыг үүнээс өмнө хүлээн зөвшөөрсөн байв. Тэд XX зууны цоо шинэ нөхцөл ХМХ-ээс нийгмийн хариуцлагын өөр төрлийг шаардах болно гэдгийг ойлгосон бөгөөд энэ нь хүмүүс нэлээд эрчимтэй өрнөсөн "мэдээллийн хувьсгал"-ыг ойлгож, үнэлж эхэлсэн явдалтай холбоотой байжээ. Шинэ нөхцөлд хэвлэх үйлдвэр байгуулах, сонин хэвлэл гаргах, радиостанцийн үйл ажиллагааг хэвийн явуулахад ихээхэн бэрхшээл учирч, асар их

хэмжээний мөнгө шаардах болжээ. Янз бүрийн улс төрийн үзэл бодлыг тусгадаг маш олон жижиг мэдээллийн хэрэгсэл оршиж байсан нь хүмүүс хүссэн мэдээллийг чөлөөтэй сонгоход бэрхшээл учруулж байв. Тухайн үед (1956 он) Америкийн хотуудын зөвхөн 7 хүрэхгүй хувь нь өдөр тутмын сонинтой байсан бөгөөд янз бүрийн эздэд харъяалагдах өрсөлдөх чадвар бүхий сонин ч хуруу дарам цөөн байжээ. Телевизийн 3 сүлжээ, радиогийн 4 сүлжээ, 3 мэдээллийн агентлаг америкчуудын гэртээ хүлээж авах мэдээллийн ихэнх хэсгийг бүрдүүлж байсан бөгөөд энэ нь авторитаризмын үеийн нэгэн адил хэвлэл мэдээлэл цөөхөн тооны хүмүүсийн гарт төвлөрч эхэлсэн юм. Гэхдээ хэвлэл мэдээллийн эздийн ихэнх хэсэг нь улс төрийн удирдагчид байсан учраас ХМХ-ийг төр, засгаас хүчтэй хамгаалж байв. Хэвлэл мэдээлэлд тавих хяналт улам нарийсч хэвлэл мэдээллийн эзэд, удирдагчдад шинэ түгшүүр төрүүлж, Милль, Жефферсон нарын тодорхойлж байсан “үзэл бодлын чөлөөт зах зээл” болох тэр боломж алдагдаж эхэлжээ. Тиймээс Хэвлэлийн эрх чөлөөний комисс “хэвлэл мэдээллийг засгийн газрын хөндлөнгийн оролцооноос хамгаалж байгаа нь хүн болгон санасан бодсоноо илэрхийлэх боломжоор хангах баталгаа биш юм. Хэвлэл мэдээллийн эзэд болон удирдагчид л олон түмэнд ямар баримт, мэдээллийг өгөхийг өөрсдөө шийдэж байна”⁶

гэж тэмдэглэсэн байдаг. Ийм нөхцөл байдлаас төрсөн болгоомжлол хариуцлагатай эрх чөлөөний онолыг хөгжүүлэхэд нөлөөлжээ. Ийм онолыг баримтлагчид төр засаг ба хэвлэл мэдээллийн монопол байдал тэднийг нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг болгож, нийгмийн бүх хэсэг бүлэг, давхаргын төлөөлөгчид санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах замаар хүмүүс өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэхэд нөлөөлөхүйц хангалттай мэдээлэл байх ёстой гэж үзэж байв. Хэрэв ОНМХ тийм хариуцлага хүлээхгүй бол тэдний үйл ажиллагааг хянадаг олон нийтийн байгууллага үүсгэн байгуулах шаардлага гарч ирнэ гэдэгт тэд итгэлтэй байсан юм.

Энэ онолын үндсийг Хокингийн бүтээлүүд, Хэвлэлийн эрх чөлөөний комиссын дүгнэлт, ХМХ-ийн ёс зүйн кодексууд, практик сэтгүүлчдийн санал бодол бүрдүүлж байв. Онолын гол зорилго нь ХМХ олон түмнийг мэдээллээр хангах, зугаацуулах, аливаа зөрчил сөргөлдөөнийг хэлэлцүүлгийн аргаар шийдвэрлэхэд оршино. ХМХ-ийг олон нийтийн санаа бодол, хэрэглэгчдийн үйл ажиллагаа, мэргэжлийн ёс зүй зохицуулдаг. Хувь хүний эрх, эрх чөлөө болон нийгмийн онцгой чухал эрх ашигт халдахыг хориглодог. Сэтгүүл зүйн бусад онолоос ялгагдах гол онцлог нь ХМХ нийгмийн өмнө хариуцлага хүлээх ёстой, хэрэв эс тэгвэл хэн нэгэн тийм байхыг шахаж

шаардах эрх эзэлж болдогт оршино. Үзэл бодлоо илэрхийлэх сонирхолтой ямар ч хүн ХМХ-ийг эрхлэн гаргах боломжтой бөгөөд хэвшлийн хувьд төрийн бус бие даасан байх онцлогтой юм.

Иргэний болон эрх зүйт төр хөгжих тусам олон нийтийн мэдээллийн үйл ажиллагааны эрх чөлөөний үндсэн зарчмыг хадгалахын хамт ОНМХ-ийн үйл ажиллагааг эрх зүйн үүднээс зайлшгүй зохицуулах шаардлага тулгарсан юм. Энэ нь ОНМХ-ийн хариуцлагатай эрх чөлөөний үзэл баримтлалыг боловсруулахад хүргэсэн ажээ. Германы Үндсэн хуулинд мэдээллийн эрх чөлөөг тунхаглаж, цензурыг хориглосон заалтын дараа шууд энэ эрхийн хэм хэмжээг тусгай хуулиудаар зохицуулах талаар тусгасан нь санамсаргүй зүйл биш юм. Энэ бол хууль тогтоох засаглал ОНМХ-ийн үйл ажиллагааны эрх чөлөөний хэм хэмжээг зохицуулсан хууль гаргах, түүгээр дамжуулан үгийн эрх чөлөөг хэтрүүлэн хэрэглэхийн эсрэг тэмцэх эрхтэйг илэрхийлсэн хэрэг мөн. АНУ-д ч хэвлэлийн эрх чөлөө дээрхийн адил юм. Хэвлэлийн болон үг хэлэх эрх чөлөөг хязгаарласан хууль гаргахыг Үндсэн хуулиар хориглосон боловч АНУ-д үгийн эрх чөлөө, Үндсэн хуулийн анхны нэмэлт өөрчлөлтөөс иш татах боломжийг ашиглах хэм хэмжээг тодорхойлсон маш олон эрх зүйн акт (хуулиуд, АНУ-ын дээд шүүхийн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх

тайлбар, муж улсуудын бие даасан хуулиуд, ОНМХ-ийн практик үйл ажиллагаанд харгалзан үзэх үлгэрчилсэн заавар зөвлөмж болох шүүхийн шийдвэрүүд) байдаг.

Сэтгүүл зүйн үйл ажиллагааг эрх зүйн үүднээс зохицуулж, хөгжүүлж ирсэн хэд хэдэн чиглэл байдаг. Үүнд:

Нэгдүгээрт, энэ бол төр засгийн ашиг сонирхлыг хамгаалах явдал юм. Германы Үндсэн хуулинд: "Үзэл бодлоо илэрхийлэх... эрх чөлөөг чөлөөт ардчилсан дэглэмийн эсрэг тэмцэхийн тулд ашигласан хүн болгон энэхүү үндсэн эрхээ хасуулах болно. Үндсэн эрхээ хасах, түүний хэм хэмжээг Холбооны улсын Үндсэн хуулийн шүүх тодорхойлно" гэж тэмдэглэсэн байдаг. АНУ-ын Дээд шүүх Үндсэн хуулийг тайлбарлахдаа шүүгчдийн бодлоор ОНМХ "Хорлон сүйтгэх ажиллагаа явуулах", төр засагт "илэрхий, зайлшгүй аюул занал учруулах", "хортой санаа бодлого агуулах", "өдөөн хатгалга хийх" тохиолдолд хэвлэлд цээрлэл хүлээлгэх боломжтой гэж үздэг. Их Британид "засгийн дээд эрхийг баригчийн, Нэгдсэн Хаант төрийн Үндсэн хуулийн засаглалын, парламентын аль нэг танхим, эсвэл шүүхийн системийн нэр хүндийг олны өмнө гутаах", "хааны албатуудын дунд дургүйцэл төрүүлэхийг", "энэхүү харьяатуудын доторх янз бүрийн анги давхаргуудын хооронд дайсагнал, өш хорсол төрүүлэхийг" өдөөх, эсвэл төрийн тэргүүнийг

доромжлох зорилготой хэвлэлийн болон аман бүтээл тараахыг гэмт хэрэгт тооцдог. Мөн Англид "үл мэдэгдэх" хэмээх систем байдаг бөгөөд түүнд орсон жагсаалтын дагуу үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулахуйц мэдээлэл тараахыг хориглосон ажээ. Түүнчлэн дэлхийн аль ч оронд төрийн болон цэргийн нууцын тухай хууль бий. Дайн байлдааны үед цензур (хяналт) тогттоодог. Холбооны байгууллагууд (тухайлбал, Англи болон АНУ-д) "санаанд үл нийцэх" сонин хэвлэлийг хүргэхээс татгалзах, радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулахыг хориглох (Англид) эрхтэй байдаг ажээ.

Хоёрдугаарт, энэ бол хувь хүний хуулийн ашиг сонирхол болон эрхийг хамгаалах явдал юм. "Хүний эрхийг хамгаалах түгээмэл тунхаг" болон НҮБ-ын батлан гаргасан бусад баримт бичгүүдийн үзэл санааны дагуу аливаа улс орон иргэний, төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын болон бусад үндсэн эрхийг хуулиар баталгаажуулах, хүний эрхийг ямар нэг байдлаар, түүний дотор ХМХ-ээр зөрчихөөс хамгаалах үүрэгтэй. Захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, нотолгоогүй гэм буруутанд үл тооцох, арьс өнгө, яс үндэс, нас, хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглох, хувь хүний халдашгүй дархан байдал, амьдралын хэрэгцээг, түүний дотор мэдээллийн хэрэгцээг хангах үүрэг, итгэл үнэмшил, үзэл бодол,

санаагаа чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээллийг хүлээж авах, тараах болон бусад эрх зэргийг сэтгүүлч сайн мэдэж байхын хамт түүнийг дээд зэргээр хамгаалах ёстой. Хүнийг гүтгэх, доромжлох, арьс өнгө, яс үндэс, анги давхаргаар гадуурхаж дайсагнахыг, өдөөн хатгахыг хуулиар шийтгэдэг.

Зарим оронд диффамаци буюу үнэн бодит баримтад үндэслэгдсэн боловч хүний нэр төрийг гутаан доромжилсон мэдээлэл тараасны төлөө хуулийн хариуцлагад татдаг. Хэрэв тийм мэдээлэл тараасныг шүүх "санаатай үйлдэл" гэж үзвэл ял шийтгэдэг. Түүнчлэн хүмүүсийн болон янз бүрийн байгууллагын эдийн засгийн эрх ашгийг (техник, технологийн нууц, арилжаа худалдааны нууц, хадгаламж болон гэрээслэлийн нууц г.м.) бас хамгаалдаг. Ингэхдээ төр, нийгмийн нэртэй хүмүүсийн талаарх мэдээлэл харьцангуй "нээлттэй", бага хамгаалагдсан байхад хувь хүмүүсийн талаарх мэдээлэл "нээлттэй бус" арай өндөр хамгаалалттай байх онцлогтой юм.

Үндсэн хууль болон бусад хууль эрхийн актуудад заасан хүрээнд сэтгүүлчдийн эрх чөлөөний (эрх ба үүрэг) хэм хэмжээ тодорхойлогдоно.

Хэдийгээр бүх оронд бус боловч дэлхийн олон оронд сэтгүүлчийн болон хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой эрх зүйн заалт, тогтоомжийг ХМХ-ийн тухай хуульд тусгасан байдаг.

Ишлэл

- ¹ Зулькафиль М. 2004. Сэтгүүл зүйн онол. УБ., х. 76.
- ² Сиберт Ф.С. и др. 1998. Четыре теории прессы. М., с. 39.
- ³ Прохоров Е. П. 2003. Введение в теорию журналистики. М., с. 168.
- ⁴ Мильтон Ж. 2001. О свободе печати // История печати. М., с. 40.
- ⁵ 1996. Речь М.Робеспьера о свободе печати. М., с. 7-8.
- ⁶ Сиберт Ф.С. и др. Указ. соч., с. 20.

Ашигласан бүтээл

1. Березин В. М. 1997. Теория массовой коммуникации. М.
2. Дэннис Э., Мэррилл Д. 1998. Беседы о Масс-Медиа. М.
3. Зулькафиль М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.
4. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
5. Мильтон Ж. 2001. О свободе печати // История печати. М.
6. Прохоров Е. П. 2002. Журналистика и демократия. М.
7. Прохоров Е.П. 2003. Введение в теорию журналистики. М.

8. Сиберт Ф. С. и др. 1998. Четыре теории прессы. М.

9. 1996. Речь М. Робеспьера о свободе печати. М.

10. Merrill J., OdeU S.J. 1983. Philosophy and Journalism. New York.

Резюме

Статья посвящена раскрытию сущности и особенностей "Четырех теорий прессы", разработанных американскими теоретиками и историками 50 лет тому назад. В каждой из четырёх теорий проблема ответственности прессы находила решение, соответствовавшее тем социальным и политическим структурам, в рамках которых функционировала пресса. Сегодня проблемы социальной ответственности СМИ остаются в центре внимания журналистов, политиков, владельцев и издателей и широкой общественности. Особенно остро они обсуждаются в Монголии-свобода печати, завоеванная в процессе демократической и перехода к рыночной экономике, столкнулась с экономическими трудностями и сложностями отношения с государственными структурами. Поэтому знание о четырёх теориях прессы имеет большое значение в развитии свободной журналистики в Монголии.